

“Улаанбаатар сан” ХХК-ний Түүхчилсэн лавлах

Түүхийн хэсэг :

- Байгууллага үүсэх болсон түүхэн нөхцөл байдал :

1996 оны үед хотын даргаар ажиллаж байсан Ж.Наранцацралт Нийслэл хотын төсөв хүрэлцээ муутай, хөрөнгө оруулалт дутагдалтай байсан учир хотыг санхүүгийн хувьд бие даалгах, хотын эдийн засаг, санхүүгийн чадавхийг дээшлүүлэх арга саам хайж, хотын удирдлагаар ажиллаж байсан хүмүүс тухайлбал Л.Дугаржав, Л.Энэбиш, С.Мөнхжаргал, С.Балбар, Б.Цэдэв, Б.Намхайнямбуу, Ч.Авдай, Г.Ганхуяг, Л.Байгаль, Э.Золбаяр гэх зэргээр төрийн болон бизнесийн байгууллага, эрдэмтэн мэргэд маш олон хүмүүстэй ярилцан зөвлөлдөж, тэдний олон сайхан санаа, дэмжлэгийг авч, хотын өмнө тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэх, зах зээлийн эдийн засгийн харилцааны менежментийг бүрдүүлэх, хотыг санхүүгийн хувьд бие даалгах, эдийн засаг санхүүгийн чадавхийг дээшлүүлэх, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийг хөгжүүлэх “Улаанбаатар сан” -г санаачлан НИТХ-ын дарга Баасанжавт танилцуулж, 1997 онд НИТХ-ын шийдвэрээр байгуулсан юм.

- Байгууллагын чиг үүргийг гүйцэтгэж байсан өмнөх байгууллагын нэр : 1960-иад оны үед Хотын санхүүгийн хэлтэс сугалаа гаргах зэргээр төсөвт тусгай сан бүрдүүлж байсан тухай ахмадууд дурсаж байсан.
- Байгууллага анх байгуулагдсан, өөрчлөн зохион байгуулагдсан, татан буугдсан он, сар, өдөр:
 - НИТХ-ын Тэргүүлэгчдийн 1997 оны 02 сарын 6-ны өдрийн 02 тоот тогтоолоор Нийслэлийн эрхзүйн байдлын тухай хуулийн анх “Улаанбаатар сан”-г байгуулсан.
 - НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2000 оны 04 сарын 26-ны өдрийн 50 тоот тогтоолоор “Улаанбаатар сан”-г улсын үйлдвэрийн газрын статустай болгож өөрчилсөн.
 - НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2002 оны 01 сарын 30-ны өдрийн 14 тоот тогтоолоор “Улаанбаатар сан” УҮГ-ыг өөрчилж, “Улаанбаатар сан” хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчилсөн.
- Байгууллагын албан ёсны бүтэн нэр
“Улаанбаатар сан” ХХК
- Байгууллагын зорилт, чиг үүрэг, тэдгээрийн өөрчлөлт
 - Сан статустай үед Нийслэл хотын эдийн засаг, хот байгуулалт, түүний дэд бүтцийг хөгжүүлэх, хотын нийтийн аж ахуйг өргөтгөж, хүн амын хангамж үйлчилгээ, нийгмийн асуудлыг сайжруулах, байгаль орчныг хамгаалах зорилготой,
 - УҮГ статустай үед Нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх, түүний төсөв, санхүүгийн чадамжийг нэмэгдүүлэх зорилготой, орон нутгийн өмч дээр үндэслэсэн, Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг ашигын төлөв хуулийн этгээд гэж өөрчилсөн.

- ХХК статустай үед Нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх, хот тохижилтыг сайжруулах, хотын төсөв, санхүүгийн чадамжийг нэмэгдүүлэх, иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий нийслэлийн өмч дээр үндэслэгдсэн, аж ахуйн тооцоотой, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах хуулийн этгээд гэж өөрчилсөн.

Үндсэн чиглэл нь :

- Нийслэл Улаанбаатар хотын хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтанд хөрөнгө оруулэх
- Нийслэлийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх
- Хүн амын ажиллаж амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийн зорилтыг биелүүлэхэд чиглэх

- Байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, харьяа газрын бүрэлдэхүүн

Үндсэн үйл ажиллагаа нь:

НИТХТ-ийн тогтоолын дагуу Нийслэл Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг хөгжүүлэх, хот тохижилтыг сайжруулах, хүн амын үйлчилгээг боловсронгуй болгох, нийгмийн асуудлыг сайжруулах, экологи, байгаль, орчныг хамгаалах, үйлдвэрлэл, худалдаа үйлдвэрлэл, аялал жуулчлал зэрэг бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулах Үүнд:

- 1 Рекламны "Ulaanbaatar Color" хулдаасан хэвлэлийн үйлдвэр: /4 ажилтантай/

- Хулдаасан хэвлэл –
- Фото хэвлэл
- Даавуу, мод, төмөр гэх мэт бүхий л зүйл дээр хэвлэл
- эх бэлтгэл бэлтгэх үйлчилгээ үзүүлдэг.

- 2 Рекламны самбар түрээслүүлэх : /Самбарын тасаг 2 ажилтантай/

Орчин үеийн гэрэлтүүлэгтэй, стандарт шаардлага хангасан самбарууд түрээслүүлж, өлгөж буулгах үйлчилгээ үзүүлдэг.

3. Автогараж түрээслүүлэх /Төв компани/

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр, Тасганы овоонд 30 машины дулаан автогаражийн барилгыг барьж ААН байгууллагуудад түрээслүүлж байна.

- 4.Төсөл хөтөлбөр боловсруулах, Хотын хөрөнгө оруулалтын ажилд тодорхой хөрөнгө гаргах


- Хотын төсвийн ачааллыг багасгах, санхүүгийн хөрөнгийг арвижуулах зорилгоор төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, тендер зарлах, сугалаа, хувьцаа үнэт цаас гаргах зэргээр санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж Нийслэлийн эдийн засаг санхүүгийн шинэ бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх
Үүнд: Санхүүгийн байгууллагад хөрөнгө оруулж, хувь эзэмших
 - Улаанбаатар хотын банк
 - Улаанбаатар хотын даатгал ХХК –д
- Олон улсын байгууллага, гадаад орны засаг захиргаа, бизнесийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран компанийн үндсэн үүрэгт нийцсэн үйл ажиллагаа явуулах
- Хуулиар хориглоогүй бизнесийн бусад салбарт үйл ажиллагаа явуулах зэрэг болно.
- Төрийн байгууллагын тогтолцоо болон эдийн засаг, нийгэм- улс төр, соёл, шинжлэх ухааны амьдралд тухайн байгууллагын эзэлж буй байр суурь

Тус компани нь :

1. Нийслэлийн өмчит компаний хувьд Нийслэлийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэхэд бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлж байгаа ба татвар, ногдол ашиг хэлбэрээр төсөвт хувь нэмрээ оруулахаас гадна нийслэлийн хөрөнгө оруулалтын ажилд санхүүжилт хийдэг онцлогтой компани юм. Мөн бизнесийн хөрөнгө оруулалт нийслэлийн өмч хөрөнгийг нэмэгдүүлэх,
2. Хуримтлагдсан хөрөнгийн 60 хувийг Хотын хөрөнгө оруулалтын ажлууд нь нийгэмд чиглэсэн жишээлбэл: нийтийн эзэмшлийн гудамж талбайг тохижуулах, замын гэрэлтүүлэг, гэрлэн дохио, шинээр орон сууцны дундах инженерийн шугам сүлжээ, гэр хорооллын цахилгаан хангамж,
3. Хөшөө дурсгалын ажил, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, цас мөсөн урлагийг хөгжүүлэх зорилгоор Мөсөн хотхон, Улаанбаатараар овоглосон байгууллагуудыг уриалан урлаг соёл, спортын арга хэмжээг зохион байгуулах, Монгол улс, Нийслэл хотоо сурталчлах гадаадад “Монгол фестиваль” зохион байгуулах, хандив цуглэжслах өргөн цар хүрээтэй ажиллаж ирлээ.


- Байгууллагын үйл ажиллагаатай холбогдож гарсан тоон мэдээ, статистик зэрэг харьцуулсан тоон үзүүлэлт

Нийт зардлыг ерөнхийд нь ангилж үзүүлбэл:



Компанийн нийт орлогын 50-90 хувийг Нийслэлийн хөрөнгө оруулалтын ажилд шууд зарцуулж байв


Нийслэлийн хөрөнгө оруулалтыг зардлыг бүтэц:



Компаний дүрэм, чиг үүргийн дагуу нийслэлийн эдийн засаг нийгмийн зорилтод тусгагдсан ажлуудад хөрөнгө гаргаж, Нийслэлийн харьяа мэргэжлийн байгууллагуудаар хяналтыг хийлгэж, хамтран ажиллаж ирлээ.

Handwritten mark

Цэвэр ашгийн муруй




Тус компани нь 2002 оноос эргэн төлөгдөхгүй, компанид хөрөнгө болж үлдэхгүй нийслэлийн хөрөнгө оруулалтын шууд зардлуудыг багасгаж, эргээд санд орлого орох үр дүнтэй бизнес тулхуу хөрөнгө оруулалтыг хийх бодлого барьж ажилласны үр дүндэй ажигтай ажиллаж, хуримтлагдсан цэвэр ашгаасаа нийслэлийн төсөвт ногдол ашиг хэвээр хэлбэрээр хувь оруулах, мөн давхар нийслэлийн хөрөнгө оруулалтын ажилд хөрөнгө гаргаж нийслэл хотынхоо хөгжилд хувь нэмрээ оруулж байна.

Байгууллагын нэр болон харьяалалын өөрчлөлт хийгдээгүй.
 "Улаанбаатар сан" ХХК хэвээр байгаа. Нийслэлийн өмчит аж ахуйн нэгж /100 хувь/


Байгууллагын бүтэц, түүний өөрчлөлт

Тус компани нь удирдлагын босоо тогтолцоотой.



Ажлын алба буюу компаний үйл ажиллагаа өргөжиж, дотоод бүтэц нэмэгдсэн.

Компаний дотоод бүтэц



Хөмрөгийн түүхийн хэсэгт:

- Хөмрөгийн баримтыг архивт анх хүлээн авсан он, сар, өдөр болон хөмрөгийн баримтын он цагийн хязгаар, тоо хэмжээ
Анх 2000 он 1 сард хүлээн авч /1997-1999оныг хамарч 55 хадгаламжийн нэгж бүртгэгдсэн./ 1997-2007 оны 11 сарын байдлаар нийт 246 хадгаламжийн нэгж байна.
- Хөмрөгийн баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээнд орсон өөрчлөлт, тэдгээрийн шалтгаан
 - *Баримтын бүрэлдэхүүнд Видео бичлэг, баримтат кино , гэрэл зургийн баримтууд нэмэгдсэн. Тоо хэмжээ жил бүр нэмэгдэж байгаа.*
- Хөмрөгийн баримтын бүрэн бүтэн байдал, хадгалалтын түвшин
Улаанбаатар сан ХХК нь цомхон, НЗДТГ дотор өрөө тасалгааны хүрэлцээ муугаас баримтуудаа зориулалтын тусгаарласан өрөөнд хадгалах боломжгүй учраас албан тасалгаанд төмөр сейфэнд хадгалдаг.
- Хөмрөгийн баримтыг эмхлэн цэгцэлсэн, тодорхойлон бичсэн байдал, онцлог
Архивын баримтуудыг стандартын дагуу эмхэлж цэгцэлсэн. Онцлог гэвэл бусад аж ахуйн нэгжүүдээс өөр Нийслэлийн хөрөнгө оруулалтын ажилд зарцуулсан хөрөнгийн баримтууд , төсөл хөтөлбөр боловсруулах, судалгааны материалууд давхар хадгалагддаг.

Хөмрөг үүсгэгч байгууллагын архивын баримт төрийн архивт болон бусад байгууллагын архивын хөмрөгт хадгалагдаж буй талаарх мэдээлэл

Байхгүй. Нийслэлийн архивт хөмрөгийн баримтуудыг хүлээлгэж өгөхөөр бэлдэж байгаа.

- Бусад байгууллага, хувь хүмүүсийн баримт хадгалагдаж буй талаарх мэдээлэл
Байхгүй..
- Байгууллагын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын үйл ажиллагаа
Ажлын алба 3 ажилтантай тул арга зүйн комисс ажилладаггүй.

Хөмрөгийн баримтын тодорхойлолтын хэсэг

- Хөмрөгийн баримтыг тэдгээрийн бүрэлдэхүүн, нэр, төрөл болон агуулгаар нь нэгтгэн дүгнэсэн товч тодорхойлолт
 - *Бичиг хэрэг /ирсэн, явсан бичиг, тушаал зиндвэрүүд/*
 - *Санхүүгийн баримт /харилцах, касс, няравын тайлангууд, байгууллагын тайлан, шинжилгээ, шалгалтын акт, дүгнэлтүүд//*
 - *Хөрөнгө оруулалтын ажлуудын баримт /Нийслэлийн хөрөнгө оруулалт/*
 - *Нийгэм, соёлын чанартай баримтууд /мөсөн хотхон, сугалаагаар нийгмийн худал шийдэгдсэн хүмүүсийн баримт, олон нийтийн дунд зохион байгуулсан ажлууд, олон улсад зохион байгуулсан үзэсгэлэн гэх мэт*
- Хөмрөгийн эрдэм шинжилгээний лавлах, тэдгээрийн бүрэлдэхүүн
 - *Төсөл, судалгааны материал баримтууд*
- Хөмрөгийн баримтын ашиглалтын байдал /зорилго, хэлбэр/ зэргийг тусгаж бичих
 - *Ажлын хэрэгцээнд*
 1. *Төсөл хөтөлбөрийг үргэлжлүүлэх, шинээр болосруулах, тайлан төлөвлөгөө, шинжилгээ хийхэд өмнөх хөмрөгийн материалыг ашигладаг*
 2. *Аудит, Хяналт шалгалтын байгууллага*
 - *Иргэд, Аж ахуйн нэгжид архивын лавлагаа гаргаж өгөхөд ашиглах*